



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/04

Бөхт

Соёлын төвийн бүтэц орон тоог  
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын төвийн 2024 оны бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.
2. Манлайлах ур чадвараа дээшлүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хариуцлагатай, идэвх санаачилгатай хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ

4826010003

2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн  
А\04 тоот захирамжийн хавсралт

№	Албан тушаал	Албан тушаалын зорилго, чиг үүрэг
1	Соёлын төвийн дарга	Төрөөс баримтлах соёлын бодлого, салбарын болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтыг хангах хүрээнд нутаг дэвсгэр дэх хүн амыг соён гэгээрүүлэх, үйл ажиллагааг дэмжсэн соёл, урлагийн олон талт ажлыг зохион байгуулж, бус нутгийн онцлог соёлын өвд тулгуурласан үнэт зүйлийг судлан хөгжүүлэх ажлыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар ханган соёлын төвийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг ажил олгогчийн өмнө хариуцана.
2	Номын санч	Орон нутгийн хэмжээнд хүн амд ном хэвлэлийг сурталчилах ажлыг шуурхай зохион байгуулах, соёлын баримтат өвийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх. номыг цахим үйлчилгээнд хамруулах
3	Өвийн ажилтан	Төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сум орон нутагтаа хэрэгжүүлэх танхимын сан хөмрөгийн баяжилт, бүртгэл, үзүүлэн дэлгэх, судалгаа хийх, сурталчлах ажлыг гардан зохион байгуулах, Түүх соёлын дурсгалт зүйлийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтад байнга хяналт тавьж бүрэн бүтэн байдлыг хариуцах
4	Бүжгийн багш	Төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сум орон нутагтаа хэрэгжүүлэх сумын иргэдэд бүжгийн боловсролоор дамжуулан иргэншүүлэх, ардын бүжгийг сурталчилах хойч үедээ өвлүүлэн үлдээх. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад тогтоомж заавар, журам, стандартын дагуу байгууллагын албан хаагчдын эд хөрөнгө болон бусад холбогдох материалаар тасралтгүй ханган үйл ажиллагааг явуулах, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн өмчийн хадгалалт, хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдал, анхан шатны бүртгэлийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах
5	Дуу хөгжмийн багш	Төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сум орон нутагтаа хэрэгжүүлэх сумын иргэдэд хөгжмийн боловсролоор дамжуулан төлөвшүүлэх, хөгжмийн боловсролд сургах, соёл хүмүүжлийн олон талт ажлыг зохион байгуулах, ардын урлагийн өв санг судлан ажиллах
6	Үйлчлэгч	Соёлын тухай хууль болон төрөөс баримтлах соёлын бодлого, үндэсний хөтөлбөрийг сум орон нутагтаа хэрэгжүүлэх, иргэдийн соёл чөлөөт цагийн үйл ажиллагаа болон ажилтануудын ажиллах тав тухтай цэвэр орчин бүрдүүлэн, тасралтгүй нөхцөл бололцоог ханган ажиллах